



Milí přátelé,

předně děkuji za krásné a povzbuzující ohlasy na naše první číslo. Moc si toho vážíme.

V průběhu února jsme vstoupili do roku ohnivého koně. Přeji Vám, aby Vám tento rok přinesl energii, zdraví a radost ze života. Ať je to rok nových příležitostí, odvahy a kreativity.

V tomto čísle najdete fotoreportáž z výstavy mongolských umělců v ČR, která právě probíhá u nás v kanceláři. Srdečně Vás tímto zveme k návštěvě. V případě zájmu nás kontaktujte.

S velkou radostí Vám také oznamujeme, že jsme již zveřejnili online katalog mongolských výroků a služeb MON-BIZ. Pokud máte zájem být součástí seznamu, stačí nám napsat a my Vás tam rádi umístíme.

Určitě si nenechte ujít rozhovor s mongolskými studenty z Ústavu jazykové a odborné přípravy v Poděbradech.

A samozřejmě, pokud byste měli zájem zveřejnit nějakou zajímavou informaci, zde máte prostor.

Příjemné čtení!



Tsagaan Sar by Fux Karachovič

Эрхэм найзууд аа,

Манай мэдээллийн товхимлын анхны дугаарт өгсөн таны сайхан, урам зориг өгсөн санал сэтгэгдэлд чин сэтгэлээсээ талархаж байна.

Хоёрдугаар сард бид Гал морин жилийн босгыг алхлаа. Энэ жил та бүхэнд эрч хүч, эрүүл мэнд, амьдралын баяр баяслыг авчирч, шинэ боломж, зориг, бүтээлч санаагаар дүүрэн байх болтугай.

Энэ дугаарт та манай оффист болж буй Монгол уран бүтээлчдийн үзэсгэлэнгийн фото сурвалжилгыг үзэх боломжтой. Та бүхнийг хүрэлцэн ирж сонирхохыг урьж байна.

Мөн Монгол бизнес эрхлэгчид, бүтээгдэхүүн, үйлчилгээний MON-BIZ онлайн каталоги аль хэдийн нийтлэгдсэнийг баяртайгаар мэдэгдэж байна. Хэрэв та энэ жагсаалтад нэгдэхийг хүсвэл бидэнд бичээрэй.

Подєбрады дахь Хэлний болон мэргэжлийн бэлтгэлийн институтийн монгол оюутнуудтай хийсэн ярилцлагыг мөн уншихаа бүү мартаарай.

Хэрэв та сонирхолтой мэдээ, мэдээлэл нийтлүүлэхийг хүсвэл сар бүрийн дунд хүртэл бидэнтэй холбогдоно уу.

Та бүхэнд таатай уншлага хүсье!

HEPATITIDA D/ D төрлийн гепатит

Znovu využíváme všechny mongolské obyvatele v České republice, aby využili možnost bezplatného testování na hepatitidu B a D. Pokud potřebujete pomoc s objednávkou nebo doprovodem na pracoviště, kde Vás otestují, rádi vám vše zařídíme a pomůžeme.

V případě potřeby Vám jsme k dispozici i v průběhu následné léčby, která by měla probíhat rovněž bezplatně. Nemusíte se obávat omezení v práci ani běžném životě – léčba nijak nesnižuje pracovní výkonnost a zdravotní údaje jsou přísně důvěrné, zaměstnavatel se o diagnóze nedozví. V případě zájmu nás neváhejte kontaktovat.

Бид Чех улсад амьдарч буй бүх Монгол иргэдийг В болон D гепатитын үнэ төлбөргүй шинжилгээнд хамрагдах боломжийг дахин ашиглахыг уриалж байна. Хэрэв танд цаг захиалах эсвэл шинжилгээ хийх газарт очиход тусламж хэрэгтэй бол бид бүхнийг зохион байгуулж, танд баяртайгаар туслах болно.

Мөн шаардлагатай тохиолдолд дараагийн эмчилгээний явцад ч бид танд дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна. Энэ эмчилгээ мөн үнэ төлбөргүй байх ёстой.

Та ажил болон өдөр тутмын амьдралдаа ямар нэгэн хязгаарлалт гарах вий гэж санаа зовох хэрэггүй. Эмчилгээ нь ажиллах чадварт нөлөөлдөггүй бөгөөд эрүүл мэндийн мэдээлэл хатуу нууцлалтай хадгалагдана — ажил олгогч таны оношийг мэдэхгүй.

Хэрэв та сонирхож байвал бидэнтэй чөлөөтэй холбогдоорой.

Таны эрүүл мэнд, Таны ирээдүй!

ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДААРЫ.
Та өөрийгөө болон ойр дотныхоо хүмүүсээ хамгаалаарай.

Зарим өвчнүүд урт хугацаанд ямар ч шинж тэмдэггүй байж болох ч эрүүл мэндэд тань ноцтой хохирол учруулж болзошгүй.

ЦАГ АЛДАХГҮЙ ШИНЖИЛГЭЭ = ЦАГ АЛДАХГҮЙ ЭМЧИЛГЭЭ

Эдгээр өвчнүүдийн тухай мэдэх чухал зүйлс:

- HIV ХАЛДВАР**
 - Цусар, бэлгийн замаар, эхэс уурт дамждаг.
 - Бурэн эмчлэх боломжгүй боловч вирусийг бие махбодид дарах эмчилгээ бий.
 - Эрт илрүүлэлт урт наслах, чанартай амьдрал болж.
- В ТӨРЛИЙН ШАР ӨВЧИН**
 - Цус, бэлгийн замаар, эхэс уурт дамждаг.
 - Эцэг гэмтээж болзошгүй.
 - Хроник хэлбэрийг эмчилж болно.
 - Урьдчилан сэргийлэх вакцинтай!
- С Т ТӨРЛИЙ ШАР ӨВЧИН**
 - Цусар (иншээ нь ариун бус орчинд шивээс хийлгэж, мансууруулах бодис эзэлтгэж, мөнх нь цус савтай эзэлтгэж) дамждаг.
 - Удаан хугацаанд элгийг гэмтээж, хамгийн хүнд тохиолдолд элгийн хорт хавдарт хүргэж болзошгүй.
 - Сайн мэдээ: Эмчилгээтэй бөгөөд эгний, өвдөлтгүй!
- D ТӨРЛИЙН ШАР ӨВЧИН**
 - Зөвхөн В төрлийн шар өвчний эрэгт хэлбэрийг хүмүүст тохиолддог.
 - Удаан хугацаанд элгийг гэмтээж, хамгийн хүнд тохиолдолд элгийн хорт хавдарт хүргэж болзошгүй.
 - Бурэн эмчлэгдэх боломжгүй ч эмчилгээ бий.



ШИНЖИЛГЭЭ ХЭРХЭН ЯВАГДДАГ ВЭ?

- ✓ Түргэн бөгөөд ихэнх тохиолдолд өвдөлтгүй
- ✓ Нээлттэй төвүүд ба шинжилгээний цэгүүд:
 - Нэрээ нууцалж болно, үнэ төлбөргүй
- ✓ Мэргэшсэн төвүүд:
 - Эрүүл мэндийн даатгалаар үнэ төлбөргүй

Иргэний дугаар эсвэл бусад үнэмлэх шаардлагатай

ХААНА ШИНЖИЛГЭЭ ӨГЧ БОЛОХ ВЭ?


Дэлгэрэнгүй мэдээлэл болон байршлуудыг:



WWW.TESTUJSEVCAS.CZ

С вирусийн эрэгт гепатитийн эмчилгээний мэргэшсэн төвүүд

ЭРҮҮЛ МЭНД БОЛ ХАМГИЙН ҮНЭТ ЗҮЙЛ
Бүү хүлээ – өнөөдөр шинжилгээ өг.



Cilead Sciences s. r. o., IČO 24268551, Pujmanově 1753/0a, 140 00 Praha 4 – Nusle | CS-UNB-0761

OBSAH/АГУУЛГА

Hepatitida D
D төрлийн гепатит

Nabídka pomoci pro mongolské rodiče/
Монгол эцэг эхчүүдэд зориулсан тусламж

Rozhovor s Mongolskými studenty/
Монгол оюутнуудтай хийсэн ярилцлага

Katalog Mongolských podnikatelů
Монгол бизнес эрхлэгчдийн каталог

Oznámení
мэдэгдэл

Fotoreportáž z výstavy mongolských umělců/
Монгол уран бүтээлчдийн үзэсгэлэнгээс фото сурвалжилга

Výzva pro rodiče mongolských dětí - Монгол хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зориулсан уриалга

Máte mongolské dítě v české škole a potřebujete poradit se školním systémem, integrací nebo komunikací se školou? Ozvěte se nám. Ve spolupráci se spolkem Mongolských matek připravujeme pravidelná setkání pro rodiče i děti, kde vám rádi pomůžeme a propojíme vás s dalšími rodinami. Termíny setkávání ještě doladujeme. Pokud ale máte zájem se potkat na živo či online, ozvěte se nám.

Таны хүүхэд Чехийн сургуульд сурч байна уу? Чехийн боловсролын тогтолцоо, хүүхдийн тань дасан зохицол, сургуультай харилцах талаар зөвлөгөө хэрэгтэй бол бидэнтэй холбогдоорой. Бид эцэг эх, хүүхдүүдэд зориулсан тогтмол уулзалтуудыг бэлтгэж байна.

Téma měsíce/ Сарын сэдэв

Mongolští studenti v ČR - sny, odvaha a nové začátky

V únoru jsem měla možnost mluvit s několika mongolskými studenty, kteří v České republice studují češtinu a připravují se na další vysokoškolské studium. Ptala jsme se jich na první dojmy, sny i na to, co by si podle nich Češi měli vyzkoušet z mongolského způsobu života. Jejich odpovědi jsou upřímné a inspirativní.

Nomin Yeruult popisuje svůj první dojem z České republiky s nadšením:

„První dojem o České republice byl krásný. Všude jsou senzační budovy, historické památky, cítila jsem se jako ve filmu.“ Největší výzvou byla jazyková bariéra, ale díky učitelům se rychle zlepšuje. Ráda by studovala stavební inženýrství, protože „to je budoucí žadané“. A co bychom si měli vyzkoušet my? „Spěte ve stanu na břehu a poslouchejte zvuk řeky... Věřím, že budete milovat nomádský život.“

Také Bujinlkham Gantumur přijela bez předchozí osobní zkušenosti s Českem, ale na základě pozitivních doporučení. Dnes říká: „Svým mongolským přátelům budu Českou republiku chválit, protože je to klidné a pohodlné místo pro život a velmi se mi líbí chování a přístup místních lidí.“ Pro Nominjin Sainbaatar je snem stát se učitelkou matematiky: „Už od dětství mě matematika baví a mým snem je učit děti. Myslím si, že učitel je velmi důležité povolání.“ Z české historie ji zaujal zejména Karel IV. a Karlův most. A Čechům by doporučila vyzkoušet si pastevecký život na venkově, ke kterému má díky své rodině blízký vztah.

Velmi osobně mluví o své budoucnosti Gantsatsral Batbukh:

Po období adaptace chce „žít naplno“, najít si oblíbenou českou knihovnu, hádat se s přáteli v hospodě o politice – a hlavně „pochopit pointu českého vtipu hned, bez toho, aby mi ho někdo musel vysvětlovat.“ Čechům doporučuje vyzkoušet tradiční pozdrav zolgokh, který vyjadřuje úctu ke starším a propojuje generace. Některé věci studenty překvapily. Maralmaa Khashtsetseg například zmiňuje: „Nejvíc mě překvapilo, že pečivo je v obchodech volně vystavené.“ Nejtěžší je pro ni čeština a orientace v městské dopravě.

Nomin-Erdene Batbayar přiznává, že jí chybí „rozlehlé mongolské stepi“ a svobodná otevřená krajina. Z Česka si chce naopak odvézt zkušenosti s technologiemi, infrastrukturou a kulturními programy, aby jednou mohla přispět své vlasti. Zaujala nás i její myšlenka o „dalekém čase“ – mongolském přístupu, kdy lidé méně podléhají přesným harmonogramům a více respektují rytmus přírody.



Podobně mluví i Purevsuren Ganzorig, která by uvítala zjednodušení administrativy pro zahraniční studenty. Přesto dodává: „Ano, po určité době jsem se v České republice začala cítit jako doma.“ Velkou roli podle ní hraje přátelskost Čechů i zdejší příroda. Nomin-Erdene Tumennasan by Českou republiku popsala jako „krásnou zemi s bohatou historií“ a jejím cílem je dokončit studium a najít dobrou práci.

Khorolsuren si Česko vybrala kvůli kvalitním technickým univerzitám a bezpečnému prostředí. Janganyм Aitugan považuje za nejtěžší češtinu, ale oceňuje klid města, který jí připomíná domov. A Bat-Erdene Otgonbaatar si chce z Česka přivést především suvenýry a mince jako vzpomínku na toto období.

Z jejich odpovědí je patrné, že studium v zahraničí není jen o vzdělání a překonávání jazykové bariéry. Velice děkují i jejich paní učitelce Kateřině Pokorné, která tyto studenty zde v ČR doprovází.

Чех улсад суралцаж буй монгол оюутнууд — мөрөөдөл, зориг, шинэ эхлэлүүд

Хоёрдугаар сард би Чех улсад чех хэл суралцаж, цаашдын их сургуулийн боловсролдоо бэлтгэж буй хэд хэдэн монгол оюутантай ярилцах боломжтой байлаа. Би тэднээс Чех улсад ирсэн анхны сэтгэгдэл, мөрөөдөл, мөн монгол ахуй амьдралаас чех хүмүүс юуг туршиж үзвэл сонирхолтой байх талаар асуусан юм. Тэдний хариултууд чин сэтгэлийн бөгөөд урам зориг өгөм байлаа.

Номин Еруүлт Чех улсын талаарх анхны сэтгэгдлээ баяртайгаар хуваалцжээ: “Чех улсын талаар миний анхны сэтгэгдэл маш сайхан байсан. Хаа сайгүй гайхалтай барилгууд, түүхэн дурсгалуудтай, яг л кинонд байгаа мэт санагдсан.” Хамгийн том сорилт нь хэлний бэрхшээл байсан ч багш нарынхаа ачаар хурдан сайжирч байна. Тэрээр ирээдүйд барилгын инженер мэргэжлээр суралцахыг хүсдэг бөгөөд “энэ бол ирээдүйд эрэлттэй мэргэжил” гэж үздэг. Харин чех хүмүүст хандан тэрээр: “Голын эрэг дээр майхан барьж унтаад, голын чимээг сонсоорой... Та нүүдэлчдийн амьдралд дурлах болно гэдэгт итгэлтэй байна” гэж зөвлөжээ.

Бужинлхам Гантөмөр мөн Чех улсад өмнө нь ирж байгаагүй ч эерэг зөвлөмжүүдийн дагуу иржээ. Өнөөдөр тэрээр: “Би Монгол дахь найз нөхөддөө Чех улсыг магтан ярьна. Учир нь энд амьдрахад тайван, тухтай орчинтой бөгөөд нутгийн хүмүүсийн харилцаа, хандлага надад маш их таалагдсан” гэж хэлж байна.

Номинжин Сайнбаатарын мөрөөдөл бол математикийн багш болох. “Би багаасаа математикт дуртай байсан, хүүхдүүдэд заах нь миний мөрөөдөл. Багш гэдэг маш чухал мэргэжил гэж боддог.” Чехийн түүхээс түүнд ялангуяа Карл IV болон Карлын гүүр их сонирхолтой санагджээ. Харин чех хүмүүст тэрээр хөдөө нутагт мал маллаж амьдрах туршлагыг үзэж харахыг зөвлөж байна. Энэ амьдралын хэв маяг түүнд гэр бүлийнх нь ачаар ойр байдаг.

Ганцэцэг Батбөх ирээдүйнхээ талаар маш хувийн бодлоо хуваалцжээ. Дасан зохицох үе өнгөрсний дараа тэрээр “амьдралыг бүрэн дүүрэн мэдрэхийг” хүсэж байна — дуртай чех номын сангаа олох, найзуудтайгаа шар айрагны газар сууж улс төрийн талаар маргах, мөн хамгийн гол нь “чех хошигнолын утгыг хэн нэгнээр тайлбарлуулахгүйгээр шууд ойлгодог болохыг” хүсдэг. Тэрээр чех хүмүүст уламжлалт золголт ёсыг туршиж үзэхийг зөвлөж байна. Энэ нь ахмад настнаа хүндэтгэх, үе үеийг холбох утгатай ёс юм.

Зарим зүйл оюутнуудыг гайхшруулжээ. Жишээлбэл, Маралмаа Хашцэцэг: “Намайг хамгийн их гайхшруулсан зүйл бол талх, нарийн боов дэлгүүрүүдэд ил тавигддаг явдал” гэж хэлсэн. Харин түүнд хамгийн хэцүү нь чех хэл болон хотын нийтийн тээврийн системд дасах байжээ.

Номин-Эрдэнэ Батбаяр Монголын “өргөн уудам тал нутаг” болон чөлөөтэй, нээлттэй байгаль орчноо их санаж байгаагаа хэлсэн. Харин Чехээс тэрээр технологи, дэд бүтэц болон соёлын хөтөлбөрүүдийн талаар туршлага авч, нэг өдөр эх орондоо хувь нэмрээ оруулахыг хүсэж байна. Түүний ярьсан “алсын цаг” гэх ойлголт бидний анхаарлыг татсан. Энэ нь монголчуудын амьдралын хэмнэл бөгөөд хүмүүс яг нарийн хуваарьт бага баригдаж, байгалийн хэмнэлийг илүү хүндэтгэдэг гэсэн санаа юм. Ижил төстэй бодлыг Пүрэвсүрэн Ганзориг мөн хэлсэн. Тэрээр гадаад оюутнуудад зориулсан захиргааны зарим үйл явцыг илүү хялбар болговол сайн гэж үздэг. Гэсэн хэдий ч тэрээр нэмж хэлэхдээ: “Хэсэг хугацааны дараа би Чех улсад өөрийгөө яг л гэртээ байгаа мэт мэдрэж эхэлсэн.”

Түүний хэлснээр чех хүмүүсийн найрсаг зан болон эндхийн байгаль энэ мэдрэмжийг бий болгоход чухал үүрэгтэй. Харин Номин-Эрдэнэ Түмэннасан Чех улсыг “баялаг түүхтэй, үзэсгэлэнтэй орон” гэж тодорхойлж, сургуулиа амжилттай төгсөж, сайн ажил олохыг өөрийн зорилго гэж хэлсэн.

Хоролсүрэн Чех улсыг чанартай техникийн их сургуулиуд болон аюулгүй орчинтой учраас сонгосон байна. Жанганым Айтуганын хувьд хамгийн хэцүү нь чех хэл боловч хотын тайван уур амьсгал нь түүнд эх орноо санагдуулдаг гэж хэлжээ. Харин Бат-Эрдэнэ Отгонбаатар Чех улсаас энэ үеийн дурсгал болгон голчлон бэлэг дурсгалын зүйлс болон зоос авч явахыг хүсэж байна.

Тэдний хариултаас харахад гадаадад суралцах нь зөвхөн боловсрол эзэмших, хэлний бэрхшээлийг даван туулах тухай биш юм. Эдгээр оюутнуудыг Чех улсад дэмжин, хамтран ажиллаж буй тэдний багш хатагтай Катержина Покорнад ч мөн чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Mongolští podnikatelé

Milí podnikatelé a partneři,

naš online katalog **MONBIZ** je nyní spuštěn! Najdete jej na našich webových stránkách (odkaz [zde](#)). Katalog je přehledně řazen podle kategorií podnikání či typu nabízených výrobků a služeb. Součástí je také mapa, která usnadňuje vyhledávání, a jednoduchý proklik vás přímo přenesne na webové stránky jednotlivých podnikatelů.

Vyzýváme všechny mongolské podnikatele působící v České republice, aby se k nám připojili. Pomozte nám vytvořit živý, aktuální a silný katalog, který bude podporovat vzájemné propojení komunity a zároveň důstojně reprezentovat mongolské podnikání směrem k české veřejnosti.

Těšíme se na spolupráci!

Эрхэм бизнес эрхлэгчид, ТҮНШҮҮД ЭЭ

Манай **MONBIZ** онлайн каталог одоо албан ёсоор нээгдлээ! Та үүнийг манай вэбсайтаас ([энд холбоос](#)) үзэх боломжтой. Каталог нь бизнесийн чиглэл болон санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр ойлгомжтой ангилагдсан. Мөн хайлтыг хялбарчлах газрын зурагтай бөгөөд энгийн дарж орох холбоосоор та тухайн бизнес эрхлэгчийн вэбсайт руу шууд шилжих боломжтой.

Бид Чех улсад үйл ажиллагаа явуулж буй бүх монгол бизнес эрхлэгчдийг бидэнтэй нэгдэхийг урьж байна. Хамтдаа амьд, байнга шинэчлэгддэг, хүчирхэг каталогийг бүтээж, хамтын нийгэмлэгийн харилцаа холбоог бэхжүүлж, мөн монгол бизнесийг чех олон нийтэд нэр төртэйгээр танилцуулцагаа.

Хамтын ажиллагааг тэсэн ядан хүлээж байна!

POZVÁNKY/МЭДЭГДЭЛ

Společnost česko-mongolského přátelství a spolupráce

Klub přátel Asie Pražská jurta

Dovolujeme si pozvat všechny zájemce

NA PŘEDNÁŠKU DR. JIŘÍHO ŠÍMY
Aleš Hrdlička v Mongolsku, Číně a na Sibíři

14. března 2026 od 14:00
Kancelář SČMPS: Svidnická 506, Praha 8
(vchod branvou vpravo)

vstupné dobrovolné

www.czechmongol.cz 721 945 139

Srdečně Vás zveme na přednášku dr. Šímy o Aleši Hrdličkově, zajímavé osobnosti, která působila krom jiného i v Mongolsku.

Na další měsíce plánujeme:

- účast na Euroasijském fóru
- workshop hrdelního zpěvu
- setkání s mongolskými studenty
- finisáž výstavy mongolských umělců
- prezentaci na festivalu národnostních menšin
- akci v ZOO Praha

Та бүхнийг доктор Шимагийн Алеш Хрдличкагийн тухай лекцэд урьж байна. Тэрээр сонирхолтой хувь хүн бөгөөд өөр олон орны зэрэгцээ Монголд ч ажиллаж байсан юм.

Ирэх саруудад бид дараах арга хэмжээнүүдийг төлөвлөж байна:

- Евразийн форумд оролцох
- Хөөмийн сургалт, воркшоп
- Монгол оюутнуудтай уулзалт
- Монгол уран бүтээлчдийн үзэсгэлэнгийн хаалтын арга хэмжээ
- Прага 8 дүүргийн фестивальд танилцуулга
- Прагийн амьтны хүрээлэнд зохион байгуулах арга хэмжээ

Chcete Newsletter a další zajímavosti dostávat pravidelně emailem do Vašich schránek?

Přihlašte se k odběru na našem webu:

<https://czechmongol.cz>

- Napište nám, co by se Vám v Newsletteru líbilo číst?
- Sdílejte jej se svými přáteli.
- Staňte se našimi spoluautory.

Манай мэдээллийн товхимол (newsletter) болон бусад сонирхолтой мэдээллийг тогтмол имэйлээр хүлээн авахыг хүсэж байна уу?

Манай вэб сайтаар дамжуулан захиалгад бүртгүүлээрэй:

<https://czechmongol.cz/mn/>

- Манай мэдээллийн товхимолд ямар сэдвийн талаар уншихыг хүсэж байгаагаа бидэнд бичээрэй.
- Найз нөхөдтэйгөө хуваалцаарай.
- Манай хамтран зохиогч болоорой.

FOTOREPORTÁŽ Z VÝSTAVY MONGOLSKÝCH UMĚLCŮ
МОНГОЛ УРАН БҮТЭЭЛЧДИЙН ҮЗЭСГЭЛЭНГЭЭС ФОТО СУРВАЛЖИЛГА



Ojunggerelin Gerelzul



Enkhzol Batjargal



Bayanmunkh Battulga




Gunchin Ichinkhorloo



Suchtomor Urtanasan



Dolgorma Zagdradnaa



Bayarnmaa Jambaldorj
